Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

# БИЕИЙН ТАМИР,СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2025 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ЖИЛИЙН ТАЙЛАН

*Улаанбаатар хот*

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилго-1 Идэвхтэй амьдралын хэв маягтай хүн амыг 3 хувиар нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| Зорилт-1.1 Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх хүчин чадлыг сайжруулах, бие бялдрын хөгжлийн сорилын суурь үзүүлэлт, идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ-1.1.1 Биеийн тамир, спортын салбарын хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулах | 980.0 | Боловсруулалтын хувь | - | 100% | Монгол улсын 2025 оны тодотгосон төсвийн дагуу салбарын төсвөөс нийт 9.1 тэрбум төгрөгийн зардлын санхүүжилт хасагдсан бөгөөд түүнтэй уялдуулан БТСУХ/20250103026/03/01 дугаартай БТС-ын салбарын цогц стратеги боловсруулах олон улсын зөвлөх үйлчилгээний 980.0 сая төгрөгийн тендер шалгаруулалтын ажлыг цуцалсан. | - |
| 2 | Арга хэмжээ 1.1.2 Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын | | | | | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох суурь үзүүлэлт 76392 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын хэмжээнд авах удирдамжийг баталж, нэгдсэн зохион байгуулалтаар авч, тайлан боловсруулж, дүгнэх | 100.0 | | 67.7 % | Хамрагдалт -68 хувь тайлан-4 | хамрагдсан А,В,С үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь,<br>• А-19300 буюу 25.2%,<br>• В-22121 буюу 28.9%,<br>• С-13500 буюу 17,6%<br>Үлдсэн 28,05 хувийг D, F эзэлж байна. А,В,С үнэлгээтэй 54921 иргэн хамрагдаж 71,8%-ийг эзэлж байна. Хүн амын бялдрын түвшин тогтоох сорилыг 04-64 насны иргэдийн биеийн үндсэн ачаалал даах чадвар, хамрагдсан байдлаар<br>0-4 нас 17429<br>5-9 нас 21277<br>10-14 нас 16221<br>15-19 нас 10612<br>20-24 нас 652<br>25-29 нас 1367<br>30-34 нас 1682<br>35-39 нас 1987<br>40-44 нас 161<br>45-49 нас 1407<br>50-54 нас 1295<br>55-59 нас 622<br>60-64 нас 229<br>Нийт эрэгтэй 38197 буюу 50%<br>Нийт эмэгтэй 38195 буюу 50% эзэлсэн байна. | 100% |
| 3 | Арга хэмжээ 1.1.3<br>Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг | - | | - | 100% | Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах анхан шатны хэмжилтийн 3 төхөөрөмж, бие бялдрын сорилын 7 төхөөрөмжөөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх хүчин чадлыг сайжруулах нэгдсэн мэдээллийн системийн программ хангамжийг хөгжүүлэх | | Төсөл боловсруулалтын хувь | | | хүний биеийн бүтцийн 13 үзүүлэлтийг дэлгэрэнгүй харуулдаг анхан шатны шинжилгээний аппарат өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хүчин чадлыг сайжруулах нэгдсэн мэдээллийн систем, программ хангамжийн үзүүлэлт дээр үндэслэн 1558 иргэд сорил хамрагдаж 727 эрэгтэй,831 эмэгтэй, 62 аж ахуй нэгж байгууллагуудад зөвлөх туслах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна | 100% |
| 4 | Арга хэмжээ-1.1.4<br>Хүн амын амьдралын хэв маяг, идэвхтэй хөдөлгөөний мэдлэг хандлага, дадалтай иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн спортын их наадам“-ыг үе шаттай зохион байгуулах | - | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан байна | - | Спортын 6 доошгүй төрлөөр зохион байгуулж 60.000 хүнийг хамруулсан байна | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу 2025 оны 04 дугаар сарын 11-нээс 05 дугаар сарын 30-ны хооронд спортын 7 төрлөөр /Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Шатар, Үндэсний сур , Үндэсний шагай, Үндэсний харваа / 4 үе шаттай хангай, хойд, говь, төвийн 4 бүсэд зохион байгуулж явууллаа. Иргэдийн спортын их наадмын анхан шатанд 21819 иргэн, бүсийн шигшээ тэмцээнд 1790 иргэн хамрагдаад байна | 100% |
| 5 | Арга хэмжээ-1.1.5<br>Идэвхтэй хөдөлгөөний дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдрыг хөгжүүлэх, ажлын байр, амралт чөлөөт цагаар хийх дасгал хөдөлгөөний | 210.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | | 50-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхтэй хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадал, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн БТСГ, хороодод 104 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх | | | | 30.000-аас доошгүй хүн хамруулсан байна | хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 500 байгууллага аж ахуй нэгжийн 33012 хүнд зохион байгуулсан байна. | |
| 6 | Арга хэмжээ-1.1.6 Биеийн тамир, спортоор дамжуулан иргэдийн дунд биеийн тамирын арга хэмжээг цахим болон бусад хэлбэрээр зохион байгуулж идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх | 260.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | | 50-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 50.000-аас доошгүй хүн хамруулсан байна | Биеийн тамир, спортоор дамжуулан иргэдийн дунд идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, нийтийг хамарсан өдөрлөг, алхалт, гүйлт, марафон өвлийн арга хэмжээ зэрэг биеийн тамирын 575 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 230685 байгууллага, хамт олны дунд зохион байгуулж 688639 хүнийг хамруулсан байна. | 100% |
| 7 | Арга хэмжээ-1.1.7 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг төр, төрийн бус байгууллагуудтай хамтран улс орон даяар зохион байгуулах | 50.0 | 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт зохион байгуулсан байна | - | 30-аас доошгүй биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж 10.000 хүн хамруулсан байна | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд Гимнастикийн дөрвөн талт шугаман бүжгийн холбоо, алхалтын холбоо, иогийн холбоо, ахиллас ТББ, фитнес, гирийн холбоо, гар дээр суниалтын холбоодтой хамтран иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчилсан биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж 233.байгууллагын 4912 хүнийг хамруулаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Арга хэмжээ-1.1.8 Сумдад ажиллах орон тооны биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах | 80.0 | Сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаан ы тоо | 2 | Бүсчилсэн сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаа-4 | Сумдад ажиллах орон тооны биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг батлуулах журмын саналыг аймаг дүүргээс авч 1/161 тоот албан бичгээр ССАЖЗ яаманд хүргүүлсэн.<br><br>ССАЖЗ Сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/240 тоот тушаалаар “Биеийн тамирын арга зүйчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр” батлагдсан.<br><br>Хойд бүсийн Иргэдийн спортын их наадамд Иогийн холбоотой хамтарч 3 аймгаас ирсэн нийт 70 гаруй тамирчид болон иргэдэд сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгсөн.<br><br>Зүүн бүсийн арга зүйчдийн сургалтыг Дархан-уул аймагт зохион байгуулж нийт 76 хүн хамрагдлаа. | 100% |
| Зорилго-2 Мэргэжлийн спортын хөгжил, эдийн засгийн эргэлтийг дэмжих | | | | | | | |
| Зорилт-2.1Монгол Улсад зохион байгуулах олон улсын тэмцээний тоо, үр ашгийг нэмэгдүүлэх, спортын сургалт дасгалжуулалтын үр дүн сайжруулах, спортын авьяасыг нээн илрүүлж, өрсөлдөхөд чадварыг дээшлүүлэх, допингийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Арга хэмжээ 2.1.1<br>Цахим мэдээллийн санд үндэсний шигшээ багийн бус спортын холбоод, наадам, тэмцээн, арга хэмжээний талаарх мэдээлэл байршуулах | - | Хэрэгжилтийн хувь | Холбоо-35<br>Бүртгэгдсэн хүн-6730 | 100% | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат, Баяннуур хотноо 09 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд болох “Олон улсын хүүхдийн спортын XI наадам”-ын 9 төрөлд 166 тамирчдыг цахим бүртгэлд бүртгэн ажиллав Мөн Салбарын цахим сангийн ашиглалтын хүрээнд Монголын бүх ард түмний зуны спортын XVI наадмын цахим бүртгэлийг үндсэн 20 спортын төрөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8 спортын төрлөөр тус тус наадам үүсгэн зохион байгуулан ажиллаж тус наадмын анхан шат, шигшээ шатны үр дүнг мэдээллийг ил тод мэдээлэн ажиллалаа. | 100% |
| 10 | Арга хэмжээ-2.1.2<br>Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах | 300.0 | Гүйцэтгэлийн хувь | Спортын төрөл 20,<br>Хамрагдсан байгууллага 30 | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын Зохион байгуулах хороо, нэгдсэн зааврыг баталж, БТСУХ-ны даргын 2025 оны А/16 дугаар тушаалаар Орхон аймагт наадмын шигшээ тэмцээнийг зохион байгуулах нөхцөл байдлыг судлах ажлын хэсэгт шаардагдах 1,350,000 төгрөгийг, мөн даргын 2025 оны А/17 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тушаалаар наадмын шигшээ тэмцээний зохион байгуулалтын зардалд 299,999,000 төгрөгийг баталж, Ажил гүйцэтгэх 14 гэрээг байгуулан Шигшээ наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөөг 5 зорилт, 72 ажлыг гүйцэтгэхээр 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталж, албан хаагчид хэрэгжүүлэн ажилласан. Тус наадам нь "Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдье" гэсэн уриатай спортын 8 төрлийн 80 зай, ангилалд аймаг, дүүргийн 22 байгууллагын 11-17 хүртэлх насны өсвөрийн шилдгийн шилдэг 546 өсвөрийн тамирчид 478 медалийн төлөө Улаанбаатар хотын Хандгайтын мөсөн талбай (тэшүүр, шорт трейк), Чингэлтэй дүүргийн мөсөн талбай (шайбтай хоккей) болон Орхон аймгийн Сархиа цанын бааз (гүйлтийн цана, тусгай гүйлтийн цана, цасны гуталтай гүйлт, уулын цана, сноубоард)-д тус тус өрсөлдсөн. Байгууллагын нэгдсэн дүнгээр аймгуудаас Хөвсгөл аймгийн баг 20 алт, 21 мөнгө, 20 хүрэл буюу нийт 61 медальтайгаар тэргүүн байрт, дүүргүүдээс Баянзүрх дүүргийн баг 8 алт, 2 мөнгө, 12 хүрэл буюу нийт 22 медальтайгаар тэргүүн байрт шалгарсан. Монголын хүүхдийн спортын өвлийн VIII | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | наадмын нэгдсэн хөтөлбөрт багтсан үндсэн 7 спортын төрөлд амжилттай оролцож медальт байрт шалгарсан 371 тамирчин, 21 дасгалжуулагч, нийт 392 хүнд Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолоор хүн тус бүрд 200.0-600.0 мянган төгрөг хүртэлх мөнгөн урамшуулал болох 160,000,000 төгрөгийг БТСУХорооны даргын тушаалаар олгосон. | |
| 11 | Арга хэмжээ-2.1.3 Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах | 400.0 | Гүйцэтгэлийн хувь | Спортын төрөл 20, Хамрагдсан байгууллага 30 | 100% | Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмыг Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Наадмын зохион байгуулах хороо, наадмыг хоёр үе шаттайгаар зохиох нэгдсэн зааврыг БТСУХорооны даргын 2025 оны А/45 дугаар тушаалаар баталж, салбар байгууллагуудад 2025 оны 1/173 дугаар албан бичгээр хүргэж, анхан шатны тэмцээнүүд 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн дотор зохион байгуулагдахад 21 аймаг, 9 дүүргээс 15000 гаруй өсвөрийн тамирчид хамрагдаж, тамирчдын мэдээллийг Биеийн тамир, спортын наадмын цахим системд бүртгэсэн. Наадмын шигшээ тэмцээнд аймаг, дүүргээ төлөөлөн 9-17 насны өсвөрийн 6120 тамирчид 286 багц медалийн төлөө Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-ний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрөөс 06 дугаар сарын 05-ны хугацаанд 7 дүүргийн 19 байршилд нэгэн зэрэг спортын 31 төрлөөр өрсөлдсөн. Наадмын зардалд БТСУХорооны даргын 2025 оны А/129 дүгээр тушаалаар 400 сая төгрөгийг баталж, Ажил гүйцэтгэх 38 удаагийн гэрээг байгуулсан. Байгууллагын нэгдсэн дүнгээр 30 байгууллагаас өрсөлдсөнөөс Хан-Уул дүүргийн баг 36 алт, 27 мөнгө, 26 хүрэл, нийт 89 медальтай тэргүүлж, Сүхбаатар (66 медаль), Чингэлтэй (59 медаль) дүүргийн баг удааллаа.Мөн хөгжлийн бэрхшээлтэй спортын төрөлд 16 байгууллага өрсөлдсөнөөс Баянгол (13 медаль) , Сүхбаатар (9 медаль) дүүргүүд, Дархан Уул аймаг (7 медаль) эхний 3 байрт тус тус шалгарч наадмын цом, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнагдсан. МҮОНРТ-ийн MNB sport сувгаар наадмын нээлт, хаалтын ажиллагаа, шигшээ тэмцээний 10 спортын төрлийн тэмцээнийг шууд дамжуулж, БТСУХорооны пэйж хуудас, вэб сайтаар 100 ширхэг гэрэл зураг, мэдээ, рийл бичлэг 87, ярилцлага, 44 постер хийж сурталчилгааг байршуулахад 12 хоногийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд 5 сая гаруй үзэлттэй, 99119 реакшин, 8192 комент үзүүлж, БТСУХ-ны пейж хуудсыг дагагсдын тоо 4000 хүнээр нэмэгдсэн. | |
| 12 | Арга хэмжээ-2.1.4 Монголын бүх ард түмний спортын XVII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах | 450.0 | Гүйцэтгэлийн хувь | Спортын төрөл 20, Хамрагдсан байгууллага 30 | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хүрээнд Монголын бүх ард түмний зуны спортын XVI наадам 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Баянхонгор аймагт нэгэн зэрэг олимпын 16, олимпын бус 2, оюун ухааны 2, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8 нийт 28 спортын төрөлд 21 аймаг, 9 дүүргийн 3400 гаруй тамирчин, дасгалжуулагчид оролцож амжилттай зохион байгуулагдсан. Наадмын үеэр Монгол улсын дээд амжилт 18 удаа шинэчлэгдсэнээс хүндийн өргөлтийн төрөлд 11 удаа, буудлагын төрөлд 2 удаа, хөнгөн атлетикийн төрөлд 5 удаа шинэчлэгдэн тогтоогдож, Спортын мастер 9, спортын дэд мастер 10 шинээр төрөн гарсан байна.<br>Наадмыг зохион байгуулахад спортын 18 төрөлд 300 гаруй шүүгч болон Баянхонгор аймгийн төрийн болон орон нутгийн өмчит 34 байгууллагын 680 гаруй албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчид, сайн дурын 22, эмч эмнэлгийн 43 ажилтан, ажиллаж наадамд оролцогчдыг тав тухтай байлгах, аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажилласан. | |
| 13 | Арга хэмжээ-2.1.5<br>Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, хяналт тавин спортын холбоодтой хамтран ажиллах | 2.056.7 | Дэмжлэг үзүүлсэн тэмцээний тоо | Засгийн газрын 2024 оны 64 дугаар тогтоолоор Монгол Улсад 7 тэмцээн зохиогдсон. | Олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлж, хяналт тавин спортын холбоодтой хамтран ажилласан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 243 дугаар тогтоолоор Монгол Улсад 2025 онд зохиогдох олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах 11 тэмцээнийг зохион байгуулагдахаар тусгагдсан ч Монголын Снукер бильярдын холбоо, Монголын гимнастикийн холбооны санаачлагчаар Снукер бильярдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Уран сайхны гимнастикийн Ази тивийн цомын аварга шалгаруулах тэмцээнүүд зохион байгуулагдахгүйгээр цуцлагдаж үлдсэн 9 тэмцээн уралдааныг зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Тогтоолын хавсралтын нэгдүгээр заалтад тусгагдсан олимпын эрхийн оноо, дэлхийн чансаа олгох тэмцээний 2.539.000.000 сая төгрөгийн төсвийн хүрээнд 2 тэмцээн зохион байгуулагдсан (1. Биеийн тамир,спортын улсын хорооны даргын А/162 дугаар тушаалаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чөлөөт бөхийн "Улаанбаатар опэн" Дэлхийн чансааны оноо олгох тэмцээнд 1.039.500.000 сая төгрөгийн санхүүжилт, 2.Биеийн тамир,спортын улсын хорооны даргын А/214 дугаар тушаалаар Жүдо бөхийн "Улаанбаатар их дуулга 2025" Олимпын эрхийн оноо, Дэлхийн чансааны оноо олгох тэмцээнд 1.499.500.000 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон), Мөн хавсралтын хоёрдох заалтын Олон улс,Тив,Олимпын бус Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд олгох 567,728,100 сая төгрөгийн төсвийн хүрээнд 4 тэмцээнд Биеийн тамир,спортын даргын 2025 оны А/ 259,А/260, А/261, А/262 дугаар тушаалаар санхүүжилт олгож тэмцээнийг зохион байгуулсан байна. Уг тогтоолын хэрэгжилтийг хангаж нийт 6 тэмцээн уралдаанд 2,747,229,820 төгрөгийн зардлыг баталж, зохион байгуулагч спортын холбоодод төсвийг шилжүүлж зохион байгуулалтад хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаа. Одоо 3 тэмцээн зохион байгуулагдахаар төлөвлөгдөж бэлтгэл ажил хангагдаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Арга хэмжээ-2.1.6 Үндэсний шигшээ багийн бус спортын төрлийн дэлхий,тивийн наадам, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх | 301.0 | Дэмжлэг үзүүлсэн тэмцээний тоо | Дэмжлэг үзүүлсэн тоо 40 | Олимпын бус спортын төрлийн дэлхий, тивийн наадам, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлсэн байна. | Бусад спортыг дэмжих зардлын ангиллаас 17 тэмцээнд 496,080,220 төгрөгийг, Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлаас 1 ажилд 94,500,000 төгрөгийг, нийт 590,580,220 төгрөгийг гэрээгээр гүйцэтгүүлсэн. | 100% |
| 15 | Арга хэмжээ-2.1.7 Тусгай олимпын тамирчдыг олон улсын тэмцээн, наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх | 90.0 | Дэмжлэг үзүүлсэн тэмцээн, наадмын тоо | Олон улсын-3 Дотоодын-1<br><br>98,069 сая төгрөг | Тусгай олимпын тамирчдыг олон улсын тэмцээн, наадамд оролцоход дэмжлэг үзүүлсэн байна. | 1/.БТСУХ-ны даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны А/163 тушаалаар Бүгд Найрамдах Солонгос Улсын КангВон-До хотноо 2025 оны 06 сарын 27-29-ний өдрүүдэд “3х3 хамтарсан сагсан бөмбөг”-ийн Тусгай Олимпын Зүүн Азийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох багийн 3 тамирчин, 2 дэмжин тоглогч, 1 багийн ахлагч, 1 багийн дасгалжуулагчдад, нийт 7 хүнд замын зардал, байр, хоол, хувцасны зардалд 12,283,200 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>2/.Бүгд Найрамдах Итали Улсын Турин хотноо 2025 оны 03 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Турин-2025” Дэлхийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгай олимпын наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох оролцох 25 тамирчин, 9 дасгалжуулагч, 1 эмч, нийт 35 хүнд даргын 2025.02.24-ны өдрийн А/37 дугаар тушаал, 2025.02.27-ны өдрийн 38 дугаартай гэрээний дагуу 115,832,710 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, наадам 2025 оны 03 сарын 8-16-ны өдрүүдэд зохиогдоход баг тамирчид 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл медаль, нийт 21 медаль хүртсэн. | |
| 16 | Арга хэмжээ-2.1.8 Биеийн тамир, спортын экспо 2025 үзэсгэлэн зохион байгуулах | 300.0 | Сурталчилсан спортын төрөл, зохиосон үйл ажиллагаа, оролцогчдын тоо | - | Биеийн тамир, спортын экспо 2025 үзэсгэлэн зохион байгуулагдсан байна. | Биеийн тамир, спортын экспо тайлант хугацаанд үзэсгэлэн зохион байгуулагдаагүй болно. | - |
| 17 | Арга хэмжээ-2.1.9 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубийн сургалтад өсвөрийн тамирчдыг хамруулах | - | Хамрагдсан хүүхдийн тоо | Примьер лигийн Фулхэм клубийн сургалтыг 2024 онд зохион байгуулж, 11 хүүхэд сонгогдсон. | Сонгогдсон хүүхдийг сургалтад хамруулсан байна. | Монгол Улсын Засгийн газар, ССАЖЗЯамнаас хэрэгжүүлж буй “Go Mongolia” үндэсний брэндийн хүрээнд Монгол Улсын хөл бөмбөгийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх, хөл бөмбөг сонирхогч хүүхэд залуust урам зориг өгөх, спортоор хичээллэх сэдэл өгөх зорилгоор Английн мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубийн сургалтад өсвөрийн 11 тамирчдыг 2025,04,02-07-ны өдрүүдэд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан. Хөлбөмбөгийн тамирчид 04 дүгээр сарын 06-ны өдөр Фүлхэм VS Ливерпүүл тоглолтыг урилгаар үзсэн. | |
| 18 | Арга хэмжээ-2.1.10 Дэлхийн допингийн эсрэг байгууллагын татвар, ЮНЕСКО-ийн сайн дурын хандивын зардал гаргах шийдвэр гаргуулах | 120.0 | Дэлхийн допингийн эсрэг байгууллагын татвар, ЮНЕСКО-ийн сайн дурын хандивын зардал гаргах шийдвэр гаргуулсан байна. | 2023 онд татвар, сайн дурын хандивыг өгөх шийдвэр гаргуулсан. | Дэлхийн допингийн эсрэг байгууллагын татвар, ЮНЕСКО-ийн сайн дурын хандивын зардал гаргах шийдвэр гаргуулсан байна. | Дэлхийн допингийн эсрэг агентлагт жил бүрийн татварт /Wada contributions/-т 2025 оны 02 дугаар сарын 06-ны Биеийн тамир,спортын улсын хорооны даргын А/24 дүгээр тушаалаар 126,443,420 төгрөгийг албажуулав. Энэ онд Дэлхийн допингийн эсрэг байгууллагын татварт – 125,345,420₮, хандивт – 1,038,000₮ тус тус төгрөгийг төсөвлөн тушаалыг албажуулсан байна. | 100% |
| 19 | Арга хэмжээ-2.1.11 ЮНЕСКО-ийн спорт дахь допинг хэрэглэхийг эсрэг конвенц допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах | 847.0 | - | Холбогдох шийдвэр гаруулж, гэрээ байгуулж ажилласан. | Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргуулсан байна. | Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн А/128 тоот тушаалаар 390,000,000 Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих 2025 оны санхүүжилтийг олгохоор албажуулан<br>“Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц болон Допингийн эсрэг үндэсний дүрмийг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх 86 дугаартай гэрээ”-г байгуулж эхний хагас жилийн санхүүжилт олгогдоод байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилго-3 Үндэсний уламжлалт спортын наадам, нүүдэлчдийн спортын өв, соёл уламжлалыг хөгжүүлэх | | | | | | | |
| Зорилт-3.1 Нүүдэлчдийн спортын өв, соёл болсон үндэсний уламжлалт спортын наадмын шинжлэх ухааны судалгааны ажлыг өргөжүүлэх, үндэсний спортын төрлийн олон улсын тэмцээн, наадмыг нэмэгдүүлэх, орон нутгийн брэнд арга хэмжээг бий болгох ажлыг эрчимжүүлнэ. (Дотоодын аялал жуулчлалыг дэмжих) | | | | | | | |
| 20 | Арга хэмжээ 3.1.1 Үндэсний спортыг сурталчилсан “Нүүдэлчин” фестивалийг зохион байгуулах | 200.0 | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Фестиваль зохион байгуулах тухай" 41 дүгээр тогтоол, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны "Ажлын дэд хэсэг байгуулах тухай" А/211 дүгээр тушаалын дагуу 2025 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Налайх дүүрэгт зохион байгуулагдах "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийн хүрээнд зохиогдох Үндэсний спортын 5 төрлийн тэмцээнд шаардагдах зардал болох 120 сая төгрөгийн төслийг боловсруулан ЗГХА-Соёл урлагийн газарт хүргүүлж, тус газраас Монголын үндэсний спортын хороотой Ажил гүйцэтгэх гэрээг байгуулж бэлтгэл ажлыг хангуулсан. Мөн Буянт ухаа спортын ордноос 600 ширхэг цагаан сандлыг Тайж хайрхан руу 2025,08,21-ний өдөр тээвэрлэн хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн фестивалийн талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулж, нэгдсэн хөтөлбөрт үндэсний спортын 4 тэмцээн зохиогдох хуваарь, шагнал гардуулах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | | | | | | хуваарь, салбараа төлөөлөн сайдын гэрт зочлох спортын алдартнуудын нэрс, мэдээллийг гарган ССАЖЗЯаманд 2025,08,18-20 өдрүүдэд хүргүүлсэн. | |
| 21 | Арга хэмжээ 3.1.2 Нүүдэлчдийн спортын өв, соёл болсон үндэсний уламжлалт спортын наадмын шинжлэх ухааны судалгааны ажлыг өргөжүүлэх | 30.0 | Шинжлэх ухааны судалгааны бүтээлийн тоо | 1 | 1 | Тайлант хугацаанд шинжлэх ухааны судалгааны ажил хийгдээгүй байна | - |
| 22 | Арга хэмжээ 3.1.3 Үндэсний уламжлалт спортын төрлийн олон улсын тэмцээн, наадамд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, оролцоог нэмэгдүүлсэн байна. | 38.8 | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Зоос шүүрэх: Бүгд Найрамдах Казакстан улсын Шымкент хотноо 2025 оны 06 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдах Зоос шүүрэх (Тенге илу)-ийн дэлхийн анхны аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, бүрэлдэхүүнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар 7,700,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тэмцээнд 6 тамирчин оролцож 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан. | 100% |
| 23 | Арга хэмжээ 3.1.4 Үндэсний уламжлалт спортын төрлийн орон нутгийн брэнд арга хэмжээг бий болгох ажлыг эрчимжүүлэх | 50.0 | Орон нутгийн брэнд арга хэмжээний тоо | Орон нутгийн брэнд арга хэмжээ 4 | Орон нутгийн брэнд арга хэмжээг 6 болгон нэмэгдүүлсэн байна. | 1/. Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Хайчийн аманд Өвлийн аялал аялал жуулчлалын хамгийн том эвент “Хөх сувд 2025” олон улсын мөсний баяр 2025 оны 02 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд 24 дэх жилдээ зохион байгуулагдаж тэшүүр, мөсөн дээрх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | (Дотоодын аялал жуулчлалыг дэмжих) | | | | | буухиа тэмцээн, мөсөн волейболын тэмцээн, урлагийн тоглолт 4 төрлийн тэмцээн уралдааныг Хөвсгөл аймгийн ЗДТГ, Хөвсгөл аймгийн БТСГазар хамтран зохион байгуулахад 380 тамирчин хамрагдсан.<br><br>2/.Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 3 дахь жилдээ “Ерөө CUP 2025” Мөсөн сурын харвааны олон улсын нээлттэй тэмцээн эвэнт арга хэмжээ 2025 оны 02 дугаар сарын 08-09 өдрүүдэд зохион байгуулагдаж Монгол, Буриад улсын 20 багийн 200 гаруй тамирчин оролцсон.<br>3.“НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестивалийн үндэсний спортын өртөөнд 2025 оны 02 дугаар сарын 16-18-ний өдөр бэсрэг адуучин тэмцээн амжилттай зохион байгуулагдаж, тэмцээнд 2025 онд гаргасан амжилтаараа шалгарсан шилдэг 147 тамирчин дээлтэй бөх, уурга шүүрэх, ташуур шүүрэх, хашаан дотор морь уургалах, эмнэг хангал сургах, багийн буухиа зэрэг 6 төрлөөр 21 аймгийн 9 дүүргийн аварга адуучид оролцож аваргаа тодруулсан. гадаадын 100, дотоодын нийт 200-300 хүн шимтэн үзэж, Монголын адуучдын холбоо 15 хүний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрэлдэхүүнтэй ажиллаж амжилттай зохион байгууллаа. | |
| Зорилго-4 Өндөр амжилтын спортын хөгжлийг дээшлүүлэх | | | | | | | |
| Зорилт-4.1 Өвлийн спорт болон үндэсний шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэх ажлын хүрээнд өсвөр, залуучуудын ангиллын тамирчдын амжилтыг ахиулахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх | | | | | | | |
| 24 | Арга хэмжээ-4.1.1 Үндэсний шигшээ багт сонгогдсон спортын холбоодтой журмын дагуу гэрээ байгуулан улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгийг үзүүлж, дасгалжуулагч, тамирчдыг ажлын байраар ханган үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах | 14.249.2 | Холбооны тоо, Дасгалжуулагч, тамирчны тоо, Санхүүжилтийн дүн | Холбоо 26, дасгалжуулагч, тамирчид 333 Санхүүжилт 25.8 тэрбум | Холбоо-26, Дасгалжуулаг, тамирчин-314, Үйл ажиллагаанд хяналт тавьсан тоо-2 | Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын Сайдын 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/82 дугаар тушаалын дагуу Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр сонгогдсон 26 спортын холбоотой 4 болон 5 дугаар саруудад “Үндэсний шигшээ багийг олимп, паралимпын наадамд бэлтгэн оролцуулахад улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ”-г байгуулаад байна. 26 Үндэсний шигшээ багт 314 тамирчин, дасгалжуулагч, эмч ажиллаж байна. Улсын төсвөөс гэрээний дагуу санхүүгийн дэмжлэг авсан спорт холбоодын гэрээг хагас жилээр дүгнэн Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн. Үндэсний шигшээ багуудын бэлтгэл, сургалтын үйл ажиллагаанд 6 удаа хяналт тавьж хяналтын хуудсаар баталгаажууллаа. | 100% |
| 25 | Арга хэмжээ-4.1.2 Олимп, паралимпын наадам, дэлхийн аварга | 2.130.0 | | 75 хүнд | 78 хүнд | Олимп, паралимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпийн жин, зайд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгаруулах тэмцээнээс олимпын жин, зайд медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчдад сар бүр мөнгөн урамшуулал олгох | | Сар бүрийн мөнгөн урамшууллын дүн, хүний тоо | 1,896,0 тэрбум төгрөг | 2,130.0 тэрбум төгрөгийг олгосон байна. | медаль хүртсэн 11 спортын төрлийн 78 тамирчинд 2025 онд олгох Сар бүрийн мөнгөн урамшууллын хэмжээ, тамирчдын нэрсийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар 2,130,000,000 төгрөгийг (сард 177,500,000 төгрөг, улиралд 532,500,000 төгрөг, жилд 2,130,000,000 төгрөг) шийдвэрлүүлэн олгож байна. | |
| 26 | Арга хэмжээ-4.1.3 Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгох | 2.839.3 | Нэг удаагийн мөнгөн шагналын дүн, хүний тоо | 266 тамирчин,<br>59 дасгалжуулагчдад<br>2.838.0 тэрбум төгрөг | Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадам, Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам, Монголын бүх ард түмний спортын XVII наадам, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медаль | БТСУХорооны даргын 2025 оны А/130 дугаар тушаалаар 306,370,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгосон. Үүнд: Тушаалын нэгдүгээр хавсралтаар “Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдын нэрсийн жагсаалт, нэг удаагийн мөнгөн шагналын хэмжээ”-г баталж, өвлийн үндсэн 7 спортын төрөлд медальт байрт шалгарсан 371 тамирчин, 21 дасгалжуулагч, нийт 392 хүнд нэг удаагийн 160,000,000 төгрөгийн мөнгөн шагналыг олгосон.<br>2. БТСУХорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/130 дугаар тушаалын хоёрдугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүртсэн тамирчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгосон байна. | хавсралтаар “Олимп, олимпын бус төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдын нэрсийн жагсаалт, нэг удаагийн мөнгөн мөнгөн шагналын хэмжээ”-г баталж, 49 хүнд 146,370,000 төгрөгийн мөнгөн шагналыг тус тус олгосон байна. | |
| 27 | Арга хэмжээ-4.1.4 Үндэсний шигшээ багуудыг “Милан Кортина-2026” өвлийн олимп, паралимпийн наадам, “Лос Анжелес 2028” олимп, паралимпын наадамд тус тус бэлтгэн оролцуулах, наадамд оролцох эрх авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | - | Олимп, паралимпийн наадамд оролцох эрхийн тоо, тэмцээний тоо, дотоодын бэлтгэл цугларалтын тоо | “Парис-2024” олимп, паралимпын наадамд 12 төрөлд 44 эрх, “Бээжин-2022” Олимп паралимпийн наадамд нийт 5 эрх | Өвлийн Олимпын 2 эрх, паралимпн 2 эрх, Оноо цуглуулах тэмцээн 20, дотоодын гадаадын бэлтгэл, цугларалтад 10 | Цанын төрөлд 2 тамирчин өвлийн олимпын эрх аваад байна. Тэшүүрийн Үндэсний шигшээ баг БНСУ-д 2 удаа олон улсын хамтарсан бэлтгэл, 2 удаа олон улсын тэмцээнд, цанын Үндэсний шигшээ баг 1 удаа дотоодын цугларалт, 5 удаа олон улсын тэмцээнд, биатлоны Үндэсний шигшээ баг 5 удаа хамтарсан бэлтгэл болон олон улсын тэмцээнд, пара гүйлтийн цана 2 удаа олон улсын тэмцээн, 1 удаа хамтарсан бэлтгэлд, хоккейн Үндэсний шигшээ баг 2 удаа олон улсын тэмцээн, 1 удаа хамтарсан бэлтгэлд, пара уулын цана 1 удаа дотоодын бэлтгэлд тус тус хамрагдлаа. | 100% |
| 28 | Арга хэмжээ-4.1.5 “Лос Анжелес 2028” стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөө-1 төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 20 хувьд хүргэнэ | "Лос Анжелес 2028" олимп, паралимпын наадамд бэлтгэн оролцуулах тухай стратеги төлөвлөгөөний төслийг 6 ерөнхий заалттай боловсруулан Үндэсний шигшээ баг бүрдүүлсэн спорт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбоодод стратеги төлөвлөгөөний төслийг танилцуулан, хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэн төлөвлөгөөний төсөлд тусган 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/1214 тоот албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн. 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Төрийн ордон зохион байгуулагдсан "Олимп, паралимпын наадамд оролцох Үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангах Үндэсний хороо"-ны хурлаар стратеги төлөвлөгөөг хэлэлцүүлэн 2026 онд батлахаар шийдвэрлэсэн. | |
| 29 | Арга хэмжээ-4.1.6 Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон өсвөр үеийн шигшээ багийн нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулах /улсын хэмжээнд/ | 300.0 | Өсвөрийн шигшээ багийн тамирчдаас сорил авах, спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний хийх | 2024 онд 15 аймгийн Өсвөрийн шигшээ багийн тамирчдаас сорил авах, дасгалжуулагчдын сургалт-арга зүйд дүн шинжилгээ хийж,түшинг давтамжтай | Спортын 2-оос доошгүй төрөлд өсвөрийн тамирчдын нэгдсэн бэлтгэл, цугларалт зохион байгуулсан байна. | Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах "Цоохор нуга" цогцолборт 2025 оны 6 дугаар 5-15-ны өдрүүдэд чөлөөт бөхийн 17, 20 насны Ази тивийн аварга галгаруулах тэмцээний өмнөх нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулж 80 тамирчин хамрагдлаа. БТСУХ-ны даргын А/245 дугаар тушаалаар тус бэлтгэлийн зардалд 48,000,000 төгрөг зарцууллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тодорхойлсон | | | |
| 30 | Арга хэмжээ-4.1.7 Өвөл, зуны Олимп, паралимп, тусгай Олимп, дифлимпийн төрлийн шигшээ багуудад дэмжлэг үзүүлэх | 644.2 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь Тамирчдын тоо | Шигшээ багуудын оролцсон тамирчдын тоо | Амжилтын тоо нэмэгдүүлэх /медалийн тоо/ | Бүгд Найрамдах Итали Улсын Турин хотноо 2025 оны 03 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Турин-2025” Дэлхийн тусгай олимпын наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох оролцох 25 тамирчин, 9 дасгалжуулагч, 1 эмч, нийт 35 хүнд даргын 2025.02.24-ны өдрийн А/37 дугаар тушаал, 2025.02.27-ны өдрийн 38 дугаартай гэрээний дагуу 115,832,710 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, наадам 2025 оны 03 сарын 8-16-ны өдрүүдэд зохиогдоход баг тамирчид 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл медаль, нийт 21 медаль хүртсэн. Алтан медаль: Алтанзулын Азжаргал /15 настай/, Уулын цаны төрөлд хос алтан медаль Бямбасүрэнгийн Буянтогтох - Цасны гуталтай гүйлтийн 400 м-ийн төрөл, Түвдэндоржийн Солонго - Цасны гуталтай гүйлтийн 25 м-ийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрөл, Тогоочийн Дэлэгжаргал - Цасны гуталтай гүйлтийн 800 м-ийн төрөлд, Мөнгөн медаль: Алтанзулын Азжаргал -Уулын цанын төрөл, Батсүхийн Мөнх-Эрдэнэ - Бүжгийн ганцаарчилсан төрөл, Бадамлянхуагийн Бямба-Эрдэнэ - цасны гуталтай гүйлтийн 25 м, 50м-ийн төрлүүдэд хос мөнгөн медаль, Батсүхийн Мөнх-Эрдэнэ, Я.Мягмарсүрэн нар - Бүжгийн хосын төрөл, Өнербекийн Елмырза - цасны гуталтай гүйлтийн 100 м-ийн төрөл, Пүрэвдуламын Хатансайхан- цасны гуталтай гүйлтийн 400м-ийн зайн гүйлт, Амаржаргалын Идэр- Гүйлтийн цана, Агваандандарын Алтан-Очир – Снөүбоардийн төрөлд, Хүрэл медаль: Өнербекийн Елмырза - Цасны гуталтай гүйлтийн 200 м-ийн төрөл, Агваандандарын Алтан-Очир - Снөүбоардын төрөл, Магсаржавын Энхзаяа- Снөүбоардын төрөл, Эрдэнэбулганы Анхзул -Гүйлтийн цанын 50 м-ийн төрөл, Т.Дэлэгжаргал, М.Амарболд, П.Хатансайхан, Б.Буянтогтох - цасны гуталтай гүйлтийн 4x100 м-ийн зайн багийн гүйлт, Мөнхдөлийн Амарболд- Цасны гуталтай гүйлтийн 100 м-ийн төрөлд тус тус медальт байрт шалгарсан. Дифлимпын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | наадам энэ 10 дугаар сард Япон улсад зохиогдоно | |
| 31 | Арга хэмжээ-4.1.8<br>Олон улсын хүүхдийн XI наадамд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэн оролцсон байна. | 160.0 | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө засах орны Бугат хотноо 2025 оны 09 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа Олон улсын хүүхдийн XI наадамд Монгол Улсын баг спортын 9 төрөлд 160 тамирчин, дасгалжуулагч, эмч, албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэй оролцож байна | 100% |
| 32 | Арга хэмжээ-4.1.9<br>"Турино 2025" Дэлхийн оюутны өвлийн универсиад наадамд Үндэсний шигшээ багийн бус тамирчдыг оролцоход дэмжлэг үзүүлэх | 48.4 | Хэрэгжилтийн хувь | - | 100% | 1.Дэлхийн оюутны өвлийн универсиад наадмын цана, сноубоардын төрөлд оролцсон 11 хүний замын зардалд БТСУХорооны даргын 2025 оны А/28 дугаар тушаалаар 48,482,700 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, тамирчид тэмцээнд амжилттай оролцсон.<br><br>2.Бүгд Найрамдах Итали Улсын Турин хотноо 2025 оны 03 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Турин-2025” Дэлхийн тусгай олимпын наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох оролцох 25 тамирчин, 9 дасгалжуулагч, 1 эмч, нийт 35 хүнд даргын 2025.02.24-ны өдрийн А/37 дугаар тушаал, 2025.02.27-ны өдрийн 38 дугаартай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээний дагуу 115,832,710 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, наадам 2025 оны 03 сарын 8-16-ны өдрүүдэд зохиогдоход баг тамирчид 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл медаль, нийт 21 медаль хүртсэн. | |
| 33 | Арга хэмжээ-4.1.10 Харбин 2025 Азийн өвлийн спортын IX наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх | 12.6 | Хэрэгжилтийн хувь | - | 100% | БНХАУ-ын Харбин хотноо 2025 оны 02 дугаар 06-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Харбин 2025 азийн өвлийн спортын IX наадамд байгууллагын удирдлагыг оролцуулахад БТСУХорооны даргын 2025 оны А/25 тушаалаар 5,485,000 төгрөгийг, Монгол Улсын багийн штаб, хэвлэл мэдээлэл, сурвалжлага хийх, эмчийн бүрэлдэхүүнийг ажиллуулахад БТСУХорооны даргын 2025 оны А/11 дүгээр тушаалаар 12,588,400 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Томилогдсон баг бүрэлдэхүүн өвлийн наадам зохиогдсон бүх өдрүүдэд Монгол Улсын багийн штабт 08:30-20:30 цагт ажиллан үүргээ амжилттай биелүүлсэн. | 100% |
| Зорилго-5 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах | | | | | | | |
| Зорилт-5.1.1 Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 34 | Арга хэмжээ-5.1.1 Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын үйл | 20.0 | Биеийн тамир, спортын төрийн | - | Төслийг боловсруулж, батлуулаха | БТСУХ-ны даргын 2025.01.07-.ний өдрийн А/01 тушаалаар албажсан 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн хурал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийн төсөл боловсруулах | | захиргааны байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийн төсөл боловсруулсан байна. | | ар хүргүүлсэн байна. | Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж ирүүлсэн саналын хүрээнд төслийг боловсруулсан ССАЖЗЯамд хүргүүлсэн. | |
| 35 | Арга хэмжээ-5.1.2<br>Орон нутгийн Биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | 20.0 | Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо | - | 30 | Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Орон нутгийн Биеийн тамир, спортын байгууллагууд үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын талаар зөвлөгөө мэдээллийг тухай бүр асууж байгаа бөгөөд хуулийн хүрээнд зохих зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. | 100% |
| 36 | Арга хэмжээ-5.1.3<br>Биеийн тамир, спортын тухай хуулийг дагалдан гаргах журам, хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийг | - | Хэлэлцүүлэг, санал авах үйл ажиллагааны тоо | 0 | 17 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар:<br>1.“Орон нутгийн өмчийн БТС байгууллагын биеийн тамир, спортын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж төслийг хүргүүлнэ. | | | | | ажилтан, арга зүйч, дасгалжуулагчид мөнгөн тэтгэмж олгох журам”<br>2.”Допингийн эсрэг үндэсний зөвлөлийн ажиллах журам”<br>3.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл<br>4.”Биеийн тамирын дасгалжуулагч, арга зүйчийн<br>мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”<br>5.“Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын нэмэлт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”-д тус тус төсөл болон саналыг боловсруулан ССАЖЗЯ-д хүргүүлсэн.<br>6.Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон ДАШТ амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам,<br>7.Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журмын шинэчлэлтэй холбоотойгоор 2021-2023 онуудад мөнгөн шагнал авсан тамирчдын судалгааг гаргаж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журмын төсөлд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд санал хүргүүлсэн.<br>8.Дасгалжуулагчийн сургалтын хөтөлбөрийн төсөлд санал өгч, 21 аймаг, 9 дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагч, спорт клуб, спортын холбоодоор хэлэлцүүлэн, ирүүлсэн саналыг ССАЖЗЯаманд 1/161 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>9. Монголын иогийн холбооноос боловсруулсан Иогийн стандартын төсөлд санал өгч, 21 аймаг, 9 дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагч, спорт клуб, спортын холбоодоор хэлэлцүүлэн, ирүүлсэн саналыг ССАЖЗЯаманд 1/378 дугаар албан бичгээр хүргүүлсэн | |
| Зорилт-5.2 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах | | | | | | | |
| 37 | Арга хэмжээ 5.2.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах; | - | Биелэлт нэгтгэсэн тоо | 100% | 2 | Зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн зорилт, арга хэмжээний саналыг нэгтгэн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг агентлагийн даргаар баталж, Соёл,спорт,аялал жуулчлал залуучуудын сайдаар 2025 оны 02 дугаар сарын 24-нд баталгаажуулсан. Төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг нэгтгэж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьдчилсан байдлаар 2025-оны 06 дугаар сарын 16-ний өдөр ХШҮДАХэлтэс болон ССАЖЗЯ-нд хүргүүлсэн | |
| 38 | Арга хэмжээ 5.2.2 Салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тайланг нэгтгэн тайлагнах; | - | Нэгтгэсэн тайлан тоо | 11 | - | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биеийн тамир, спортын салбарт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилд 4 удаа ССАЖЗ Яаманд тайлагнасан.<br><br>-Алсын хараа 2050 Биеийн тамир, спортын салбарт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилд 4 удаа ССАЖЗ Яаманд тайлагнасан.<br><br>-Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн биеийн тамир, спортын салбарт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний 2025 оны хагас жилийн тайланг 1 удаа;<br><br>Биеийн тамир, спортын салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тайланг 2025 оны эхний хагас жил болон 9 дүгээр сарын хэрэгжилтийг https://moc.igovernment.mn/law/ сайт болон ССАЖЗ Яаманд тайлагнасан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-5.3 Биеийн тамир, спортын салбарын болон хорооны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | | | | | | | |
| 39 | Арга хэмжээ-5.3.1 Байгууллагын албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах; | 80.0 | Батлагдсан төлөвлөгөө ний тоо | Төлөвлөгөө -1 | Төлөвлөгөө хэрэгжилт | Биеийн тамир, спортын улсын хорооны даргаар Албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөөг боловсруулан батлуулсан байна. Төлөвлөгөөний хүрээнд: Удирдлагын академийн багц сургалтуудад 5 албан хаагчийг БТСУХ даргын А/298 тоот тушаалаар тус тус суралцуулахаар төлөвлөж тушаалыг албажуулсан байна. | 100% |
| 40 | Арга хэмжээ-5.3.2 Байгууллагын албан хаагчдын 2025 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах; | 90.0 | Батлагдсан төлөвлөгөө ний тоо | Төлөвлөгөө -1 | Төлөвлөгөө хэрэгжилт | 2025 оны 02 дугаар сарын 24-нд Төрийн албан хаагчийн 2025 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний I дүгээр хавсралтаар батлуулан албажуулж 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөсөн Эхний хагас жил төлөвлөлтийн хэрэгжилтийн дагуу 10 албан хаагчид 4-12 хоногийн цалинтай чөлөө олгосон байна. Мөн БТСУХ даргын А/247, А/248 тоот тушаалаар 2 алба хаагчид буцалтгүй тусламж олгосон. | 100% |
| Зорилт-5.4. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 41 | Арга хэмжээ-5.4.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай | 5.0 | Зохион байгуулсан сургалт, | Тайлан-1 | Сургалт-1 | 2025 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн, судалгаа, мэдээлэл бүрдүүлэн ажиллаж байна. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах | | үйл ажиллагаан ы тоо | | Үйл ажиллагаа-1 | | |
| 42 | Арга хэмжээ-5.4.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагаа зохион байгуулах, тайлагнах | 10.0 | Зохион байгуулсан үйл ажиллагаа, тайлангийн тоо | Тайлан - 2 | Тайлан-2 Үйл ажиллагаа-2 | 2025 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн, судалгаа, мэдээлэл бүрдүүлэн ажиллаж байна. | - |
| 43 | Арга хэмжээ-5.4.3 Хүүхдийн эрхийг хангах талаар үйл ажиллагаа зохион байгуулах, тайлагнах | 10.0 | Зохион байгуулсан үйл ажиллагаа, тайлангийн тоо | Тайлан-1 | Тайлан-2 Үйл ажиллагаа-2 | 2025 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн, судалгаа, мэдээлэл бүрдүүлэн ажиллаж байна. | - |
| 44 | Арга хэмжээ-5.4.4 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах | 5.0 | Зохион байгуулсан үйл ажиллагаа, тайлангийн тоо | Тайлан-1 | Тайлан-2 Үйл ажиллагаа-2 | Тайлант хугацаанд сургалт зохион байгуулагдаагүй байна | - |
| 45 | Арга хэмжээ-5.4.5 Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | - | Хуулийн хугацаанд хүргүүлсэн тайлан, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | 166 | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | 2025 оны эхний хагас жилд Байгууллагад ирсэн өргөдөл гомдлыг бичгээр болон 11-11 төвөөс хүлээн авч цахим сан үүсгэн, хуулийн хугацаанд 103 өргөдөл гомдлыг шийдвэрлэж сар бүрийн бичиг хэргийн болон өргөдөл гомдлын тайлан мэдээг гаргаж удирдлагад байна танилцуулж ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | Арга хэмжээ-5.4.6 Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах, тэмдэглэлт өдрүүдэд хүндэтгэл үзүүлэх | 263.9 20.0 | Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл олгох шийдвэрийн тоо, Хүндэтгэл үзүүлсэн арга хэмжээний тоо | 2 | Ахмад настанд төрөөс нэмэгдэл олгож, тэмдэглэлт өдрүүдэд хүндэтгэл үзүүлсэн байна. | БТСУХ-ны даргын Б/12 тушаалаар БТС салбарын алдар цолтой ахмад настанд нэмэгдэл олгох тушаал 119 ахмад настан А/47,А/127,А/134 тушаалаар нийт 123 ахмад настанд алдар цолтны нэмэгдэл сар бүр 150.000 төгрөгийг тус тус олгож байгаа бөгөөд эхний хагас жилийн хэрэгжилтээр 79,800,000 төгрөгийг олгосон байна.Мөн Ахмадын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх тухай тушаалаар 70 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. | 100% |
| 47 | Арга хэмжээ-5.4.7 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээн дэх арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 10.0 | Тарьсан модны тоо | Хайлаас 2520 Миндаль мод 294 | - | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хаврын мод тарих арга хэмжээнд Биеийн тамир,спортын улсын хорооны даргын 2025 оны А/131 дүгээр тушаалаар 8,987,000 Биеийн тамир, спортын улсын хорооны алба хаагчид болон Спортын ангаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Үндэсний шигшээ баг, Спортын холбоодын төлөөлөл нийт 159 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд 2240 ширхэг хайлаас мод тарьсан.<br>Намрын мод тарилтын хуваарь ирээгүй байна. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | Арга хэмжээ-5.4.8 Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах | - | Албан хэрэг хөтлөлт стандарт заавар, журамд нийцсэн байх | | Албан хэрэг хөтлөлт стандарт зааварт нийцэж, журмын хэрэгжилт хангагдсан байна. | Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гарсан дүрэм, журмыг тухай бүр мэдээлэн, Албан хэрэг хөтлөлт стандарт зааварт нийцүүлэн хэрэгжүүлж албан хэрэг бичиг хэргийн мэдээллийг сар бүр удирдлагад танилцуулан ажиллаж байна. | 100% |
| 49 | Арга хэмжээ-5.4.9 Архивын улсын үзлэгт бэлдэх | 15.0 | Архивын улсын үзлэгт орох бэлтгэл хангагдсан байх | Архивын өрөөг тохижуулсан. | Архивын улсын үзлэгт орох бэлтгэл хангагдсан байна. | 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/296 дугаар тушаалаар “Байгууллагын архивын баримт эмхэлж, цэгцлэх үйл ажиллагаанд зардал гаргах тухай” баталгаажуулан ажиллаж байна. Үүнд: Байгууллагын архивд хадгалагдаж буй 1968-2024 оны архивын баримтад иж бүрэн эрдэм шинжилгээ, нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг эхнээс нь хийж ажиллаж байна. Эрдэм шинжилгээ, нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг хийхдээ хадгаламжийн нэгжийн хуудас бүрээр нягтлан шалгаж, хөмрөгийн хамаарал, баримтын хадгалах хугацааг зөв тогтоож, он цаг, зохион байгуулалт, нэр төрөл, агуулга сэдвээр нь ангилан төрөлжүүлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэхдээ тухайн баримтын дугаар бүрийг нягтлан шалгаж, он цаг ач | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдлоор нь дараалж, дутсан болон давхардсан дугаарыг хадгаламжийн нэгжийн бүртгэлийн нэмэлт гарчигт, бүрдэл дутуу баримтын мэдээллийг баримтын байдал хэсэгт оруулан 1968-2024 оны баримтад эрдэм шинжилгээ, нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг хийж дараах данс, бүртгэл, жагсаалтыг үйлдэж ажиллаж байна. Үүнд:<br><br>*1.Байнга хадгалах баримтын данс,*<br><br>Тогтоол, захирамж, санамж бичиг, тушаал, хурлын тэмдэглэл, явуулсан бичиг, ирсэн бичиг, харилцсан бичиг, гэрээ, төсөв, төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, шалгарсан тендерийн баримт, санхүүгийн жилийн эцсийн тайлан, аудитын тайлан, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн тайлан гэх мэт тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримтын 1995-2005 оны 175 ХН-ийн бүртгэн ажиллаж байна.<br>*2.Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл,*<br><br>Газар хэлтсийн үйл ажиллагааны улирал, сарын тайлан, албан хаагчдын төлөвлөгөө, тайлан, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн гэрээ, бүртгэлийн дэвтэр, явуулсан бичиг, ирсэн бичиг, харилцсан бичиг, иргэд, албан хаагчдаас ирсэн өргөдөл, шалгараагүй тендерийн баримт, касс, харилцахын баримт, шатахууны тооцоо, бараа материалын тайлан, эд хөрөнгийн тооллогын бүртгэл, албан хаагчдын эд хөрөнгийн карт зэрэг цаг үеийн шинж чанартай баримтын 2014-2021 оны 338 ХН-ийг бүртгэн ажиллаж байна.<br>*3.70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл,*<br><br>Даргын Б тушаал, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын хувийн хэрэг, цалингийн тооцооны хүснэгт, цалингийн шилжүүлэг баримт, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн тайлан зэрэг хүний нөөцийн холбогдолтой баримтын 1968-2024 оны 235 ХН-ийг бүртгэн ажиллаж байна.<br>*4. Устгах баримтын жагсаалт*<br><br>Хадгалах хугацаа дууссан: шалгараагүй тендерийн баримт, сар, улирлын тайлан, чөлөө, ээлжийн амралт олгох хуудас, албан хаагчдын цагийн бүртгэл, тушаал, албан бичгийн төсөл, Илүү хувь: тушаалын илүү хувь, албан хаагчдын төлөвлөгөө, тайлан, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээний хуудас, төлөвлөгөө, тайлангийн илүү хувь зэрэг мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй баримтын 2009-2023 оны 32 ХН-ийг бүртгэн ажиллаж байна. | |
| 50 | Арга хэмжээ-5.4.10 Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030)-ний хэрэгжилтийг хангах салбарын үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлуулж, тайлагнах | 10.0 | Төлөвлөгөө -1<br>Тайлан -1 | 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргасан тайлан | Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж, хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны А/175 дугаар тушаалаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх агуулгыг нийгэмд түгээх зорилгоор Үндэсний шигшээ багийн тамирчдыг оролцуулан контентыг АТГ-тай хамтран бүтээв.<br><br>Тайлан хүргүүлэх хугацаа болоогүй байна | 90% |
| 51 | Арга хэмжээ-5.4.11 Албан тушаалтны ХАСХОМ, ХАСУМ-ийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах | - | Хуульд нийцүүлэн хянуулсан ХАСХОМ, ХАСУМ-ын тоо | ХАСХОМ-282, ХАСУМ-147-ыг хуульд нийцүүлэн гаргуулсан тайлан | ХАСХОМ, ХАСУМ-ыг гаргуулан, тайланг хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | Биеийн тамир, спортын салбарын нийт 144 албан хаагчийн ХАСХОМ бүртгэн тайлагнасан. Мөн 30 албан хаагчийн ХАСУМ бүртгэн тайлагнасан байна | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | Арга хэмжээ-5.4.12 Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах | - | Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажиллагаа, нууцын албан хэрэг хөтлөлт хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан байх | Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан 2024 оны тайлан | Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажиллагаа, нууцын албан хэрэг хөтлөлт хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулагдаагүй байна. | - |
| Зорилго-6.Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх, эд хөрөнгө ашиглалт сайжруулах | | | | | | | |
| Зорилт-6.1Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх, эд хөрөнгө ашиглалт сайжруулах , санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах | | | | | | | |
| 53 | Арга хэмжээ-6.1.1 Салбарын болон агентлагийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэл хийх хэлэлцүүлэг зохион байгуулах | 80.0 | Хуулийн хугацаанд нэгтгэсэн байх | - | Санхүүгийн тайлангийн нэгтгэл хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд хамааралгүй. | |
| 54 | Арга хэмжээ-6.1.2 | - | Хуваарийн тоо, | 2024 онд нийт 6 удаа | Хуваарьт өөрчлөлт | Төсвийн тодотголоор Спортын салбарын урсгал үйл ажиллагааны | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төсвийг эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалт, байгууллага, нэгжээр хуваарилан, сар, улирлын санхүүжилтийн хуваарийг боловсруулж, өөрчлөлт оруулах | | Тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх | | оруулсан байна. | төсөв 59,653.5сая төгрөг батлагдаж салбарын төсөв 9,120.7 сая.төгрөгөө буурч ирсэн ба аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир спортын газар, хороодод 31,067,0, Анагаах ухаан эрдэм шинжилгээний төвд 1,297.8, Биеийн тамир, спортын улсын хороонд 27,288.7сая.төгрөгийг тус тус хуваарилсан. Мөн төсвийг БТС-ын салбарын нийт 939 албан хаагчдаас 83 орон тоо цалингийн сан мөн хасагдаж 856 албан хаагчтай байхаар төсөв ирсэн болно. Өнгөрсөн 9 сарын хугацаанд төсвийн 6 удаагийн зохицуулалт хийж байгаа бөгөөд төсвийн санхүүжилт бүрэн олгогдохгүй хойшлуулсан нөхцөл байдал үүсэж байгаа нь зарим зардалд өр төлбөр үүсэх эрсдэл үүсээд байгааг Соёлын яам болон Сангийн яаманд уламжлан ажиллаж байна. | |
| 55 | Арга хэмжээ-6.1.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар боловсруулах | - | Төсвийн хүрээний мэдэгдэл-1 Төсвийн хязгаар-1 | Төсвийн хүрээний мэдэгдэл-1 Төсвийн хязгаар-1 | Төсвийн хүрээний мэдэгдэл-1 Төсвийн хязгаар-1 хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, төсвийн дунд хугацааны төлөвлөлт буюу төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын мэдэгдэлд саналыг боловсруулан салбарт шаардлагатай төсвийг урсгал үйл ажиллагаанд 163,789.4 сая төгрөг байхаар тооцож холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төсвийн тооцооллыг хийхдээ Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт шинээр тусгагдсан болон одоо мөрдөгдөж байгаа хууль, хэрэгжиж байгаа бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахаар төлөвлөн саналыг хүргүүлсэн. Мөн үндсэн үйл ажиллагаатай холбоотой хангамж бараа материалын зардлыг одоогийн төсвөөс 20-25 хувиар нэмэгдүүлэн тооцсон ба аймаг, нийслэл дүүргийн БТСГ-уудад нэмэгдэх орон тоог 65 албан хаагчаар цалин нэмэгдэл урамшлын зардлыг 8.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон болно. | |
| 56 | Арга хэмжээ-6.1.4 Спортын салбарын болон агентлагийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгыг яаманд хүргүүлэх | - | Төсвийн төсөл -1 | Төсвийн төсөл -1 | Төсвийн төсөл, төсөөллийг суурь түвшнээс буруулахгүй боловсруулж, хүргүүлсэн байна. | Биеийн тамир, спортын салбарын 2026 оны төсвийг 2 хөтөлбөр, 23 зориулалт арга хэмжээнд үндэслэн боловсруулсан. Соёл урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлага /71704/ хөтөлбөрт нийт 44,2 тэрбум, Биеийн тамир, спорт /71701/ хөтөлбөрт нийт 15 арга хэмжээний зардал болох 75,1 тэрбум төгрөг, нийт 119.3 тэрбум төгрөгийн саналыг холбогдох тайлбар, баримт материалуудын хамт дээд байгууллагуудад хүргүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | Арга хэмжээ-6.1.5 Агентлагийн 2025 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохицуулах; удирдлага зохион байгуулалтаар хангах | - | Гүйцэтгэлийн хувь | 2024 онд 95.8% 42.927.6 | Гүйцэтгэл бүрэн хэрэгжсэн байна. | Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны батлагдсан төсөв 32,411.7 сая.төгрөг, тодотголоор хасагдан 27,188.6 сая төгрөг болж буурсан. Үүнээс 11 хөтөлбөр арга хэмжээнд 23,687.2, үндсэн үйл ажиллагаанд 3,501.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр хуваарилсан. ССАЖЗСайдын баталсан 11 хөтөлбөр арга хэмжээний зардлын эхний 9 сарын байдлаарх хүлээгдэж буй гүйцэтгэл 18,466.2 сая төгрөг буюу 80 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 2,119.9 сая төгрөг буюу 60,5 хувь байна.<br>Салбарын хэмжээнд нийт 6 удаагийн зохицуулалтыг хийснээр Засгийн газрын 178 дугаар тогтоолоор зохион байгуулагдаж байгаа үндэсний томоохон наадмууд, мөн 174 тоот тогтоолын дагуу явагдах Олон улсын тэмцээн уралдааныг зохион байгуулан ажиллаж байна. Мөн БТС-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад туссан спортын байгууллагын ажилтан албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгохоор нийт 277 албан хаагчид 1,998.4 сая төгрөгийн тэтгэмжийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зардлыг олгох нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 58 | Арга хэмжээ-6.1.6 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн багцад хамаарах урсгал болон хөрөнгө оруулалтын зарцуулалт үр дүнгийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, хагас бүтэн жилээр нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлж, аудит хийлгэн баталгаажуулах | - | Зөрчилгүй тухай санал, дүгнэлт авсан эсэх | 2023 онд Хязгаарлалттай санал дүгнэлт гарсан. | Зөвлөмж, акт албан шаардлагын тоог бууруулж зөрчилгүй ажилласан байна. | Спортын салбарын 2024 оны санхүүгийн тайланд ҮАГ-аас орсон аудитын шалгалтаар Сөрөг дүгнэлттэй гарсан бөгөөд 2 төлбөрийн акт, 7 албан шаардлага, 7 зөвлөмжийг хүлээн авч биелэлтийг хангаж ажиллах төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэлийг 8 дугаар сард тайлагнаж ажилласан болно. | 100% |
| 59 | Арга хэмжээ-6.1.7 Төсвийн шууд захирагчийн багцад хамаарах худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах | 906.7 | Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь | 2024 оны Гүйцэтгэлийн 75% | Төлөвлөгөөний Гүйцэтгэлийн хувь 90% | Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 онд нийт 12 удаагийн 2,677.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасан. Үүнээс эхний 9 сарын байдлаар МХСН-ын медаль захиалгын тендер шалгаруулалт, Спортын төв ордны хурдны бойлуул шинэчлэх, угсрах ажил болон ордны харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг ажлыг амжилттай зохион байгуулсан болно. | 100% |
| Зорилго-7 Гадаад харилцааг хөгжүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх | | | | | | | |

| Зорилт-7.1 Биеийн тамир, спортын салбар болон агентлагийн гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | Арга хэмжээ-7.1.1 "Харбин 2025 " Азийн өвлийн X наадам, "Турин 2025 Тусгай олимпын өвлийн наадамд салбарын удирдлагуудыг оролцох арга хэмжээг зохион байгуулах | | Оролцсон арга хэмжээний тоо | | 2 арга хэмжээнд оролцсон байна. | ССАЖЗ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/27 дугаар тушаал, БТСУХ-ны 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/25 дугаар тушаалуудыг /5.485.250 төгрөг/ тус тус үндэслэн Төрийн Захиргааны удирдлагын газрын дарга О.Баттулгыг БНХАУ-ын Харбин хотноо зохион байгуулагдсан Азийн өвлийн IX наадмын Монгол Улсын баг, тамирчдын зохион байгуулалтыг ханган 2025 оны 02 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд албан томилолтоор ажилласан. Азийн өвлийн наадам нь 2025 оны 2 дугаар сарын 7-14-ний өдрүүдэд зохион байгуулагдаж 34 орны 1275 тамирчин 6 спортын төрлөөр өрсөлдсөн. Монгол улсаас нийт 35 бүрэлдэхүүнтэй шигшээ багийн тамирчид 4 спортын 7 төрөлд оролцлоо.<br><br>Биатлоны эрэгтэйчүүдийн 10 км-ын спринт уралдаанд 33 тамирчин оролцоход Монгол улсаас Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч Ц.Мөнх-Эрдэнийн удирдлага дор дөрвөн тамирчин өрсөлдөв. Манай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улсын баг тамирчдаас Э.Энхсайхан 12, Б.Анхболд 15, Ж.Гантулга 18, О.Гантулга 23 дугаар байрт хурдалсан юм. Гүйлтийн цанын буухиа төрөлд Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 5-р байранд орсон. уран гулгалтын эмэгтэйчүүдийн чөлөөт үзүүлбэрийн ганцаарчилсан төрөлд 24 тамирчин оролцсон бол манай улсаас дасгалжуулагч Тэцүкацү Накашимагийн удирдлага дор О.Мишээл (55.30 оноо), дасгалжуулагч Рина Хорегийн удирдлага дор Г.Марал-Эрдэнэ (54.72 оноо) нар чөлөөт үзүүлбэрээ үзүүлж, О.Мишээл 19 дүгээр байр, Г.Марал-Эрдэнэ 20 дугаар байрт орсон үр дүнтэй байна.<br><br><br>2. ССАЖЗ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 19-ны А/47, 2025 оны 02 дугаар сарын 20-ны А/56 дугаар тушаалууд, БТСУХ-ны даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны А/39 дугаар тушаалуудыг /48.316.632 төгрөг/ тус тус үндэслэн ЗГХА-БТСУХ-ны Гадаад харилцаа, мэдээллийг технологийн хэлтсийн дарга Н.Оюунбатыг Бүгд Найрамдах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Итали Улсын Турин хотноо зохион байгуулагдсан “Турин -2025 Тусгай Олимпын Дэлхийн өвлийн наадам”-д албан томилолтоор ажилласан. Тусгай олимпын дэлхийн өвлийн наадам нь Итали улсын Турин хотноо 2025 оны 03 дугаар сарын 08-16-ний өдрүүдэд спортын 8 төрлөөр зохион байгуулагдсан. Тус наадамд 1500 гаруй тамирчид дэмжигчидтэй оролцсон ба Тусгай хүндэт зочноор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Элчин сайд Ц.Нарантунгалаг оролцсон. Түүнчлэн, 2000 сайн дурын ажилтан, 100 орчим залуу манлайлагчид, 500 хэвлэлийн мэдээллийн байгууллагын төлөөлөгчид болон 1300 гаруй хүндэт зочид урилгаар оролцсон Тусгай олимпын хөдөлгөөнийг Саржент Шрайвер /Sargent Shriver/ олон улсын элч болох (SSGMs) тив бүсийн төлөөлөл болох манлайлагч есөн тамирчидтай хамт Тусгай Олимпын Удирдах Зөвлөлийн дарга Доктор Тим Шрайверын нээлтийн арга хэмжээний үеэр олонд хандан үг хэлсэн ба Монголын Тусгай Олимпийн Хорооны Манлайлагч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тамирчин Б.Ерөөлт нь 2024-2027 оны хугацаанд Саржент Шрайверын нэрэмжит Олон Улсын Элч Төлөөлөгчөөр (Sargent Shriver Global Messenger) сонгогдсон билээ. Тусгай олимпын хөдөлгөөний үүсгэн байгуулагчийн хүндэтгэлийн оройн зоог Үндэсний автомашины музейн (National Automobile Museum) хүлээн авалтын танхимд болсон. Хүлээн авалтад ССАЖЗ-ын Ч.Номин, Монгол Улсаас БНИУ-д суугаа Элчин сайд Ц.Нарантунгалаг, БТСУХ-ны ГХМТХ-ийн дарга Н.Оюунбат, Монголын тусгай олимпын хорооны гүйцэтгэх захирал Б.Алтанцэцэг нар оролцсон. “Турин -2025” Тусгай олимпын өвлийн дэлхийн наадамд Монголын баг тамирчид уулын цана, гүйлтийн цана, снөүборд, цасны гуталтай гүйлт, бүжиг, бөмбөгтэй заалны хоккей нийт спортын 6 төрөлд 24 тамирчин, 9 дасгалжуулагч оролцсон. Монгол Улсын баг тамирчид 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл медаль хүртсэн. | |
| 61 | Арга хэмжээ-7.1.2 Олон Улсын эрдэм шинжилгээний хурал, судалгаа шинжилгээ, сургалтын үйл | 60.0 | Оролцсон арга хэмжээний тоо | | 3 арга хэмжээнд оролцсон байна. | 2025 онд төсөв байхгүй тул тайлант хугацаанд арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд салбарын төлөөллийг оролцуулах | | | | | | |
| 62 | Арга хэмжээ 7.1.3 Өндөр хэмжээний түвшний айлчлалын мөрөөр батлагдсан ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 100.0 | Зохион байгуулсан арга хэмжээ | 2 төлөвлөгөө г батлагдсан. | 2 арга хэмжээ зохион байгуулсан байна. | Узбекстан улстай хамтран ажиллах хүрээнд хамтарсан бэлтгэл хийх боломж нөхцөлийг судлан хариу ирүүлэх тухай 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 1/424 тоот албан бичгээр Монголын чөлөөт бөхийн холбоо, Монголын жүдо бөхийн холбоонд тус тус хандаад байна. Мөн БНХАУ-ын Харбин хотод шорт трейкийн шигшээ баг зуны бэлтгэл хийх талаар тэшүүрийн холбооноос ирүүлсэн хүсэлтийг, Булган аймгийн Хангал суманд байрлах Шигшээ багийн бэлтгэлийн төвд өвлийн ордон бий болгох ажлын зургийг хийлгэх хүсэлтийг “Шигшээ багийн бэлтгэлийн төв ТӨААТҮГ”-аас БНХАУ Харбины талд уламжилж өгөхийг хүссэн хүсэлтийг 2025 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 1/443 тоот албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүллээ.<br>Монгол Улсын Гадаад харилцааны сайд ССАЖЗ-ын сайдад 2024 оны 12 дугаар сарын 30-ны 04/6140 дугаартай албан бичгээр “Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч бөгөөд Коммунист Намын Ерөнхий нарийн бичгийн дарга То Лам-ын Монгол | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсад хийсэн төрийн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталсан. Уг төрийн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 2024-2026 оны хооронд “Хоёр Улсын соёл, спортын салбар дах хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хамтарсан бэлтгэл хийх” чиглэлээр тусгасан заалтын дагуу Монголын Байт харвааны холбоо, Монголын Чөлөөт бөхийн холбоо, Монголын Жүдо бөхийн холбоотой зөвшилцөж хамтарсан бэлтгэл хийх саналыг хүргүүлсэн.<br>ССАЖЗЯ-аас Залуучууд, спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдөр албан цахим хаягаар хүлээн авсан. “Залуучууд, спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 1 дүгээр зүйл, 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйлд заагдсаны дагуу төлөвлөгөөний төсөлд саналаа тусгаж 2025 оны 04 дүгээр сарын 07-нд ССАЖЗЯ-нд албан бичгээр хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | Арга хэмжээ-7.1.4 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Премьер лигийн Фулхэм клубтэй хамтарсан сурталчилгаа хөтөлбөр хэрэгжүүлэх | 20.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 онд сургалт, сурталчлах арга хэмжээг хамтран хэрэгжүүлсэн. | 2025 оны батлагдсан төлөвлөгөөгөөр арга хэмжээ зохион байгуулсан байна. | Монгол Улсын хөл бөмбөгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх, хөл бөмбөг сонирхогч хүүхэд залууст урам зориг өгөх, спортоор хичээллэхэд сэдэл өгөх зорилготойгоор Примьер лигийн Фулхэм клубийн сургалтад 2025.04.02-07 өдрүүдэд 11 хүүхдүүдийг хамруулсан. | 100% |
| Зорилт-7.2 Салбарын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх | | | | | | | |
| 64 | Арга хэмжээ-7.2.1 Салбарын төрийн цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 20.0 | Цахим үйлчилгээний тоо | 1 үйлчилгээтэй байгаа | 2 үйлчилгээтэй болох | ГХМТХ | 100% |
| 65 | Арга хэмжээ-7.2.2 Салбарын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадмын мэдээллийн сан бүрдүүлэх | - | Спортын наадмын тоо | 0 | 3 спортын наадмын мэдээллийн сан бүрдүүлэх | Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын шигшээ шатанд оролцогч 20 байгууллагын нийт 491 албаны төлөөлөл, дасгалжуулагч, тамирчдын цахим бүртгэлийг хийж, спортын 7 төрлийн 18 байгууллагын 242 медалийн үр дүнгийн мэдээллийг байгууллагын веб сайт дээр ил тод байршуулан наадмын үйл ажиллагааны цахим санг бүрдүүлэн ажиллалаа.<br>Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатанд орон нутгийн түвшинд зохион байгуулж нийт 11549 тамирчин, дасгалжуулагчийн мэдээллийг бүрдүүлэн ажилласан бол шигшээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатанд байгууллагын нийт 30 байгууллагын 6186 албаны төлөөлөл, дасгалжуулагч, тамирчдын цахим бүртгэлийг хийн наадмын үр дүнгийн мэдээллийг байршуулан наадмын үйл ажиллагааны цахим санг бүрдүүлсэн. Наадмын хөтөлбөрт багтсан үндсэн төрлийн спортын 22 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 5 төрлийн нийт 30 байгууллагын 947 медалийн үр дүнг цахимаар гаргасан. | |
| Зорилго-8 Хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах | | | | | | | |
| Зорилт-8.1 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагаар хангах | | | | | | | |
| 66 | Арга хэмжээ-8.1.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ,үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах; | - | Хяналтад байгаа заалтуудад Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | 5 | Хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хугацаанд нь тайлагнах | ХШҮ хийх журамд заасан цаглабарын хугацаа болоогүй | - |
| 67 | Арга хэмжээ-8.1.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ,үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, | - | Хяналтад байгаа заалтуудад Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | - | Хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хугацаанд нь тайлагнах | ХШҮ хийх журамд заасан цаглабарын хугацаа болоогүй. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавих ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 68 | Арга хэмжээ-8.1.3 Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах | - | Холбогдох журмын хүрээнд баримтад тулгуурлан бодит Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | 32 | Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмжөөр хангасан байна. | Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулагдсан. Уг хяналт шалгалтын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ы өдөр баталсан “Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар, Төв аймгийн Биеийн тамир, спортын газар, Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны биелэлт, хэрэгжилтэд хяналт шалгалт хийн ажиллаж байна. Мөн Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/278 дугаар тушаалаар Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулагдсан. Уг хяналт шалгалтын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ы өдөр баталсан “Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний шигшээ багийн спортын холбоодын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны биелэлт, хэрэгжилтэд хяналт шалгалтыг тус тус хийн ажиллаж байна | |
| 69 | Арга хэмжээ-8.1.4 Хяналт шинжилгээ,үнэлгээ дотоод аудитаар чиглэлээр сургалт зохион байгуулах | 5.0 | Сургалтын тоо | 1 | 1 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын төрийн захиргааны болон төв, орон нутгийн харьяа байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Удирдлагын академийн Б байранд зохион байгуулав. Сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон харьяа байгууллага, орон нутаг, нийслэлийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Биеийн тамир, спортын газруудын хяналт-шинжилгээ, тайлан төлөвлөгөө хариуцсан 77 албан хаагч үүнээс Биеийн тамир, спортын улсын хорооны 2 албан хаагч, аймаг дүүргийн Биеийн тамир, спортын газар хороодын 29 албан хаагч хамрагдаж, оролцогчдод сургалтын гэрчилгээ олгосон. | 100% |
| 70 | Арга хэмжээ-8.1.5 Агентлагийн үйл ажиллагаанд дотоод | - | Хяналт шалгалт, | - | Хяналт шалгалт-4 тайлан-4 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр баталсан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шалгалтыг зохион байгуулах, тайлагнах | | тайлангийн тоо | | | "Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагаанд иргэний гомдолд дурдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу хийгдсэн дотоод хяналт шалгалтын тайланд туссан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар баталж, төлөвлөгөөг хариуцах газар, хэлтэст хүргүүлсэн. | |

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР